



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 1/440

Булган

┌ Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. а, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б/533 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд хэсгийн байцаагч нарын ажил мэргэжил, ур чадварыг шалгах, шилдэг албан хаагчийг шалгаруулах "Хэсгийн байцаагч 2016" улсын тэмцээнийг 2016 оны 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгуулсугай.

2. "Хэсгийн байцаагч 2016" улсын тэмцээний үйл ажиллагааны зардалд зориулж 500.000 /таван зуун мянга/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 500.000 /таван зуун мянга/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн "Архигүй Булган" хөтөлбөрт зарцуулахаар 2016 онд тусгагдсан хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



З.БАТЗОРИГ